



**ТӨР ХУВИЙН ХЭВШЛИЙН ТҮНШЛЭЛИЙН
ТӨВ ТӨРИЙН ӨМЧИТ АЖ АХУЙН ТООЦООТ
ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2025 оны 06 сарын 11 өдөр

Дугаар 4/032

Улаанбаатар хот

**Зөвлөх үйлчилгээний үнэлгээний
жишиг аргачлал батлах тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 10, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1.3 дахь заалт, Монгол улсын Засгийн газрын 2023 оны 405 дугаар тогтоолоор батлагдсан “Түншлэлийн төсөл хөгжүүлэх санг удирдах, түүний хөрөнгийг захиран зарцуулах, эх үүсвэрийг бүрдүүлэх болон зарцуулалтад хяналт тавих журам”-ын 3.1.3, 3.4, 3.5 дахь заалт, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төв төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын дүрмийн 6.7.2, 6.7.10 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль болон бусад хууль, журмын дагуу Түншлэлийн төсөл хөгжүүлэх сангийн эх үүсвэрийг бүрдүүлэх зорилгоор Түншлэлийн төслийн зөвлөх үйлчилгээний үнэлгээний жишиг аргачлалыг хавсралтаар баталсугай.

2. Төсөл хөгжүүлэхэд зориулсан судалгаа, үнэлгээний ажил, зөвлөх үйлчилгээ, Түншлэлийн төвөөс үзүүлсэн сургалтын болон хуулийн зөвлөгөө өгөхөд зарцуулсан бусад шууд зардлыг батлагдсан үнэлгээний жишиг аргачлалаар төлбөрийг тогтоож ажиллахыг Төсөл хөгжүүлэлтийн газар (А.Ганзориг)-т үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, үйл ажиллагааны биелэлтийг тайлагнаж ажиллахыг Захиргаа, санхүүгийн газар (Д.Цоож)-т даалгасугай.

ЗАХИРАЛ  М.АМГАЛАНБААТАР



"Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төв"
ТӨААТҮГ-ын Захирлын 2025 оны 06 сарын 11
өдрийн 1/05 дугаар тушаалын хавсралт

9024100894
АТУ00917 7079345

Зөвлөх үйлчилгээний үнэлгээний жишиг аргачлал

1. ТӨСӨЛ ХӨГЖҮҮЛЭЛТИЙН ҮЕ ШАТАНД ГАРАХ ТОГТМОЛ ЗАРДАЛ

Үе шат	№	Хийгдэх ажил	Хэлбэр	Хугацаа (ажлын/өдөр)	Үнэлгээ
Суурь ойлголт өгөх	1	ТХХТ тухай хуулийн танилцуулга, сургалтыг зохион байгуулах	Сургалт	1	3,000,000.00
Урьдчилсан үнэлгээ	2	Төслийн мэдээлэл, танилцуулга бэлтгэх	Гүйцэтгэх	3	2,880,000.00
	3	Хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах	Гүйцэтгэх	5	4,800,000.00
	4	Санхүү, хөрөнгө оруулалтын тооцоо гаргах	Гүйцэтгэх	5	4,800,000.00
	5	Төслийн санхүү эдийн засгийн судалгаа хийх	Гүйцэтгэх	5	4,800,000.00
	6	Санхүү, эдийн засгийн үр ашгийн шинжилгээ хийх	Гүйцэтгэх	7	6,720,000.00
	7	Судалгааг хийхэд мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлнэ	Арга зүйн зөвлөгөө өгөх	1	3,000,000.00
	8	Бодлогын баримт бичигт тусгагдсан түншлэлийн төслүүдийг сурталчлах арга хэмжээ зохион байгуулах	Гүйцэтгэх	2	1,920,000.00
	Дүн			29	31,920,000.00
Төслийн эрсдэлийг судалж тодорхойлох үе шат	9	Төслийн хүрээнд хийгдсэн ажил, баримт бичигт дүн шинжилгээ хийх	Гүйцэтгэх	5	4,800,000.00
	10	Бүрэн шинжилгээний явцад хийгдэх ажлын цар хүрээг тодорхойлох, шаардлагатай зардлын талаар арга зүйн зөвлөгөө өгөх.	Арга зүйн зөвлөгөө өгөх	1	3,000,000.00
	11	Иргэн, аж ахуйн нэгж, төрийн болон иргэний нийгмийн байгууллагуудыг оролцуулан олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулах.	Гүйцэтгэх	2	1,920,000.00
	12	Төслийн хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох судалгаа хийх	Арга зүйн зөвлөгөө өгөх	5	4,800,000.00
	13	ТЭЗҮ хийгдсэн эсэх, өмнө нь боловсруулж байсан тохиолдолд заасан агуулгын хүрээнд шинэчлэх ажлын даалгавар боловсруулахад зөвлөгөө өгөх	Арга зүйн зөвлөгөө өгөх	3	2,880,000.00
	14	Нарийвчилсан техник, эдийн засгийн үндэслэл, байгаль орчны нөлөөллийн үнэлгээ, төсөл хэрэгжүүлэх зарчим, технологийн шийдлийн талаар боловсруулагдсан материалыг хуульд нийцсэн эсэх талаар хяналт хийх	Арга зүйн зөвлөгөө өгөх	3	5,000,000.00
	15	Мөнгөний үнэ цэнийн шинжилгээ хийх	Гүйцэтгэх	5	4,800,000.00
	16	Түншлэлийн төрөл, гэрээний хэлбэр, төсөл хэрэгжүүлэх хугацааг тодорхойлох судалгаа	Гүйцэтгэх	5	4,800,000.00
	17	Төслийг хэрэгжүүлэхэд орон нутгаас үзүүлэх дэмжлэгийн төрлийг тодорхойлох	Гүйцэтгэх	2	1,920,000.00
	18	Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 7.2.4-т заасан аргачлалын дагуу эрсдэлийн шинжилгээ, судалгааг хийх	Гүйцэтгэх	10	9,600,000.00
	19	Төслийн төсөвт үзүүлэх нөлөөлөл, эрсдэл, мөн түншлэлийн гэрээний дагуу төсөвт шууд болон шууд бус төлбөрийн үүрэг, хариуцлага бий болгох эсэхийг тодорхойлох судалгаа, шинжилгээг хийх	Гүйцэтгэх	12	11,520,000.00
	20	Эрсдэлийн удирдлагын арга хэмжээ, төлөвлөгөөг боловсруулах	Гүйцэтгэх	5	4,800,000.00
	Дүн			58	59,840,000.00
Санал, Дүгнэлт	21	Бүрэн шинжилгээгээр хэрэгжүүлэх тохиромжтой гэж дүгнэсэн төслийн иж бүрэн баримт бичгийг хуулийн хяналтын хуудсын хамт боловсруулах	Гүйцэтгэх	5	4,800,000.00
Дүн				5	4,800,000.00
Сонгон шалгаруулалт	22	Сонгон шалгаруулалтын талаар ТХХТ -ийн хууль, холбогдох журмын хүрээнд суурь ойлголт өгөх сургалт	Сургалт	1	3,000,000.00
	23	Сонгон шалгаруулах баримт бичгүүдийг боловсруулах	Гүйцэтгэх	5	4,800,000.00
	24	Хууль, журмын хүрээнд сонгон шалгаруулалт зохион байгуулах гэрээнд арга зүйн зөвлөгөө өгөх	Арга зүйн зөвлөгөө өгөх	1	2,000,000.00
Дүн				7	9,800,000.00
Тогтмол зардлын нийт дүн				99	106,360,000.00
2. ТӨСЛИЙН БҮРЭН ШИНЖИЛГЭЭНИЙ ҮЕ ШАТАНД ГАРАХ ЗАРДАЛ				Төслийн төсөвт өртгийн 0.04%	